



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/403

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Хөрх булаг ХХК-ны худалдааны төвийн хойд талд )-т байршилтай Бөхт худалдаа ХХК (РД:2012588)-ийн үйлчилгээний зориулалттай 706м.кв (0,07га) газрыг Цэрэндорж овогтой Цэрэнхүү (ЗЮ:72112707)-д зориулалтаар нь шилжүүлж 20 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/436 дугаар захирамжийн Бөхт худалдаа ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000310184 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191150